



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 15 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдааныг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн төслийн тухай; “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон орлого, зардлын төлөвлөгөө, байгууллагын 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийн тухай багц баримт бичгүүдийн төслийн анхны хэлэлцүүлэг (Үүнд: ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2024 оны орлогын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2024 оны зардлын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийн төсөл); “Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай танилцуулга (ЦХХХ-ны яаманд хүргүүлэх); Харилцаа холбооны сүлжээний зохицуулалт, өнөөгийн байдлын талаар танилцуулга; Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны санал, дүгнэлтийн тухай (Хорооны 2023 оны 35 тоот, 121 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); “Хэрэглэгчийн сонголтод нөлөөлж байгаа хүчин зүйлс, харилцаа холбооны үйлчилгээний нээлттэй байдлын түвшинг тодорхойлох судалгаа”-ны танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); Бусад асуудал: “Монголын FM Радионуудын Нэгдсэн холбоо-ноос ирүүлсэн албан тоотын тухай асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны нийтдээ 11 тогтоолыг батлан шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 14 дүгээр хуралдаанаар (2023-10-31) “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн төслийн тухай хэлэлцээд, ажлын хэсэгт энэхүү баримт бичгийн төслийн талаар 2023 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 06 дугаар “Хорооны хуралдаанаас баримт бичгийн төслийн талаар өгсөн удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэх тухай (5G)” хуралдааны Тэмдэглэлээр хугацаатай удирдамж, чиглэл өгсөн болно. Хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанд ажлын хэсгээс уг тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах талаар авсан арга хэмжээ, өгсөн удирдамж чиглэлийн тусган боловсруулсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийн танилцуулга, баримт бичгийн төслийг хэлэлцээд, баримт бичгийн төслийг сонгон шалгаруулалтын процессыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах, холбогдох саналыг тусгасан Хуралдааны

тэмдэглэлийн төслийн хамт боловсруулан 2023 оны 12 дугаар сард багтаан дахин хэлэлцүүлэхийг ажлын хэсэг /З.Амгалан/-д даалгав.

Монгол Улсын Их хурлаас 2019 оны 5 дугаар сард Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг соёрхон баталсан бөгөөд энэхүү хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт (9.1.Зохицуулах хороо харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ; 9.1.16-Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах)-аар Хорооны хуралдаанаар байгууллагын жил бүрийн төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2019 оноос эхлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байгаа билээ. Түүнчлэн Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”, “Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2020 оны 65 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3.2. заалт “Хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах; (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2020 оны 65 дугаар тогтоолоор нэмсэн)”-ыг үндэслэн хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж байгаа болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанд Хорооны даргын 2023 оны А/289 тоот тушаалаар байгуулагдсан тус Хорооны гишүүн, ажлын албаны дарга А.Лувсан-Очирын ахалсан ажлын хэсэг, бүтцийн ажлын албанаас нэгтгэн боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон орлого, зардлын төлөвлөгөө, байгууллагын 2025-2026 оны төсвийн төсөөлөл”-ийн тухай (Үүнд: ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2024 оны орлогын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2024 оны зардлын төлөвлөгөө”-ний төсөл; “ХХЗХ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл; “ХХЗХ-ны 2025-2026 оны төсвийн төсөөлөл”ийн төсөл) багц баримт бичгүүдийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас хорооны дарга, гишүүдээс өгсөн санал зөвлөмж, удирдамж чиглэлийг тусган байгууллагын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн урьдчилсан тайлан болон төсвийн гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөөтэй хийсэн харьцуулалт, 2024 оны хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын томоохон хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, гадаад арга хэмжээний төлөвлөлт, төлөвлөлтийг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтийн аргачлал, бүтцийн нэгж, газар хоорондын уялдаа холбоог сайжруулах, Кибер аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх зардлын тусгах, зохицуулалтын үйлчилгээний төлбөрийн хэмжээ болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг тооцох аргачлалд шинэчлэлт хийх, хорооны санхүүгийн нөөц, чадварыг дээшлүүлэх талаар арга хэмжээг тусган боловсруулах, хорооны хуралдаанд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх, энэхүү асуудлыг багцаар нь хуралдаанд дахин хэлэлцүүлэх, батлуулах арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсэг (А.Лувсан-Очир)-т болон холбогдох бүтцийн нэгжийн газар, хэлтсийн удирдлага нарт үүрэг болгох нь зүйтэй гэж тогтов.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу тус хорооны ажлын хэсэг болон ЗБХГ-аас хамтран боловсруулсан “Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай үндэслэл, танилцуулга, эрх ашиг хөндөгдөж байгаа компани, байгууллагын төлөөлөл оролцсон уулзалт, цахим, бичгээр ирүүлсэн саналын товчоо, баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар

хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн “Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай асуудлаар хорооны хуралдаанаас зарчмын зөрүүтэй санал гараагүй тул төслийг дэмжиж, уг баримт бичгийн нэмэлт өөрчлөлт оруулах саналын төслийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд албан тоотоор хүргүүлэхээр тогтов.

Тус хуралдаанаар Харилцаа холбооны сүлжээний зохицуулалт, өнөөгийн байдлын талаар танилцуулгыг сонсож, цаашид Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд Харилцаа холбооны тухай хуульд сүлжээний тодорхойлолт, ангиллын зохицуулалтаар оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусгах талаар хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэв.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн зүйлийн 7.4.1, 7.4.2, 7.4.5 дахь заалтууд, 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 35 тоот “Тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” тогтоолыг хавсралтын хамт баталсан. Тогтоолд, Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, нээлттэй сонгон шалгаруулалт зарлах хугацаа”-г тогтоож шийдвэрлэсэн. Уг тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны 35 тоот тогтоол, хавсралтад заасан сонгон шалгаруулалтыг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацааг баримтлан Зохицуулах хорооны ажлын албанаас зохион байгуулсан болно. ХХЗХ-ны 2023 оны ээлжит 07 дугаар хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 2023 онд олгох нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, дүгнэлтийн тухай авч хэлэлцээд, тус хорооны 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 67, 68, 69, 70, 71 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг хавсралтын хамт тус тус батлан шийдвэрлэж байсан болно. Гэвч зарим нэр бүхий аймаг, орон нутагт сонгон шалгаруулалтад оролцогчийн санал ирээгүй тул Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасан нөхцөл байдал бий болж, 2023 онд багтаан сонгон шалгаруулалтыг дахин зарлах шаардлага үүссэн болно. Үүнд: Хорооны 2023 оны 35 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан 8 аймагт 8 арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл; 5 аймагт 5 өргөн нэвтрүүлгийн ТВ, 1 аймагт 1 арилжааны ТВ-ийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл; Монгол Улсын нутаг дэвсгэрт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 1 тусгай зөвшөөрөл байгаа болно. Иймээс ӨНЗГ-аас Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 10.12.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хорооны 2023 оны 35 тоот тогтоолыг тус тус үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 121 тоот “Тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай” тогтоолыг 3 хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн.

Хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар тус хорооны 2023 оны 35 тоот тогтоол, 2023 оны 121 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 2023 онд олгохоор дахин зарласан нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны тайлан, санал дүгнэлтийн тухай авч хэлэлцээд, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, Харилцаа

холбооны зохицуулах хорооны 2023 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “2023 онд олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо” болон тус хорооноос 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зарласан “Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт АРР-Орон нутаг 2023”-ын үнэлгээний ажлын хэсгийн 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн тус хорооны 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 142, 143, 144, 145 тоот тогтоолоор нэр бүхий хуулийн этгээд нарт “Нээлттэй сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг хавсралтын хамт тус тус батлан шийдвэрлэв.

Тус хуралдаанаар “Хэрэглэгчийн сонголтод нөлөөлж байгаа хүчин зүйлс, харилцаа холбооны үйлчилгээний нээлттэй байдлын түвшинг тодорхойлох судалгаа”-ны танилцуулгыг сонсов.

Бусад асуудлаар, Хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанд “Монголын FM Радионуудын Нэгдсэн холбоо”-ноос ирүүлсэн албан тоотын тухай танилцуулгыг сонсож, холбогдох Ажлын алба, Хуулийн хэлтсээс албан тоотын хариу, тайлбарыг өгөх нь зүйтэй гэж үзэв.

Энэхүү хорооны 2023 оны ээлжит 15 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 7 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 7 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 146 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдэд 7 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 147 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 148 тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2 дахь заалт, 14.12.3 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус заасны үндэслэн 2023

оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 149 тоот тогтоолын хавсралтаар 14 хуулийн этгээдийн 21 тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт болон Жавхлан ширээт ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 150 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 151 тоот тогтоолын хавсралтаар 9 хуулийн этгээдэд харилцаа холбооны сүлжээний 9 дугаарыг шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 152 тоот тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний 1 дугаар ашиглалтын хугацааг сунгаж тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-12-04